

## АЖЛЫН ДААЛГАВАР

МОНГОЛ УЛС: УХААЛАГ ЗАСАГ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ДУГААР.: 5483-MN

**Ажлын даалгавар:** Мэдээлэл, харилцаа холбооны бүх нийтийн үйлчилгээний бодлогыг сайжруулах зөвлөх үйлчилгээ

**Лавлах дугаар:** 2.1.10

### 1. Ерөнхий зүйл

Мэдээлэл, харилцаа холбоо (МХХ)-ны болон өргөн зурвасын LTE, 5G гэх мэт технологиудыг ашиглах, тэр дундаа төрийн үйлчилгээг цахимаар хүргэх зэрэг нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой болж байна.

Бүх нийтийн үйлчилгээний бодлого нь бага болон өндөр орлоготой хэрэглэгч, бага болон өндөр өртөг бүхий бүс нутгийн хэрэглэгч хоорондын тоон хуваагдлыг арилгахад чухал хэрэглүүр юм. Нөгөөтээгүүр, технологийн өөрчлөлтүүд нь бүх нийтийн үйлчилгээний төрөл болоод цар хүрээнд илэрхий нөлөө үзүүлж байна.

Иймд МХХ-ны хурдацтай хөгжилтэй хөл нийлүүлэх, иргэдийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахын тулд бүх нийтийн үйлчилгээний нэр төрөл, хамрах хүрээ, баримтлах бодлогыг шинэчлэн тодорхойлох шаардлага тулгараад байна. 2003 онд байгуулагдсан Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн үйл ажиллагаанд Монгол Улсын Сангийн яамнаас аудит хийж, холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах зөвлөмж өгсөн.

Энэхүү ажлын даалгавар нь бүх нийтийн үүргийн үйлчилгээний өнөөгийн байдал, хүчин төгөлдөр хэрэгжиж буй бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх, олон улсын шилдэг туршлага, үнэлгээнд тулгуурлан бодлогыг боловсронгуй болгох талаар зохих зөвлөмжийг өгөх зорилготой.

### 2. Зорилго

Бүх нийтийн үүргийн үйлчилгээний хүчин төгөлдөр хэрэгжиж буй бодлогын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, олон улсын шилдэг туршлага, үнэлгээнд тулгуурлан бодлогыг боловсронгуй болгох талаар зохих зөвлөмжийг санал болгох

### 3. Төслийн хүрээнд хийгдэх ажлууд

**Даалгавар 1:** Монгол Улс дахь МХХ-ны бүх нийтийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

**Даалгавар 2:** Бүх нийтийн үйлчилгээний хэрэгжилтийн талаарх олон улсын сайн туршлага судлах;

**Даалгавар 3:** Монгол Улсын бүх нийтийн үйлчилгээний бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж гаргах.

### 4. Ажлын даалгаврын дэлгэрэнгүй тодорхойлолт

4.1 МХХ-ны бүх нийтийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх:

- 4.1.1. Монгол Улс дахь МХХ-ны бүх нийтийн үйлчилгээний хууль, эрх зүйн зохицуулалтын орчны өнөөгийн байдлыг үнэлж дүгнэх;
- 4.1.2. Монгол Улсын засаг захиргааны нэгж болох сум, багийн түвшинд МХХ-ны үйлчилгээний хэрэглээ, хүртээмжтэй байдлын үнэлгээ хийх;
- 4.1.3. Сум, багийн иргэд, малчдын дижитал (цахим) ур чадварын түвшинг үнэлэх;

- 4.1.4. Монгол Улс дахь хот, суурин газрын хүн ам болон тусгай хэрэгцээтэй иргэдийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох;
- 4.1.5. Алслагдсан бүс нутаг дахь цахим эрүүл мэнд, цахим боловсрол, цахим худалдаа, цахим засаг зэрэг цахим үйлчилгээний эрэлт, хэрэгцээг үнэлэх.
- 4.2 Бүх нийтийн үйлчилгээний хэрэгжилтийн талаарх олон улсын сайн туршлага судлах
- 4.2.1. Өөр өөр арга хэрэгсэл, туршлага бүхий гурваас доошгүй улсыг хамруулан олон улсын туршлагын харьцуулсан шинжилгээг дараах байдлаар хийнэ:
- Алслагдсан бүс нутагт цахим үйлчилгээг хөгжүүлэх сайн туршлага судлах,
  - Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн үйл ажиллагааны талаар зөвлөгөө өгөх,
  - Бүх нийтийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.
- 4.2.2. ОУЦХБ, АНДЦХБ, ДШХ зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан МХХ-ны бүх нийтийн үйлчилгээний бодлогын баримт бичиг, тайлан, зөвлөмжийг судлах
- 4.3 Монгол Улсын бүх нийтийн үйлчилгээний бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж гаргах.
- 4.3.1. Дараах хүрээг хамруулан, өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ, олон улсын шилдэг туршлагад үндэслэн Монгол Улсын бүх нийтийн үйлчилгээний бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох:
- Бүх нийтийн үүргийн үйлчилгээний төрлийг дахин тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх арга, хэрэглүүрийн талаар зөвлөмж гаргах;
  - МХХ-ны бүх нийтийн үйлчилгээг ашиглахад шаардагдах тоон бичиг үсэгтэн болох төлөвлөлт, аргачлалыг боловсруулах;
  - Хот, суурин газрын зорилтот бүлгийн хүн ам болон тусгай хэрэгцээтэй иргэдэд үзүүлэх бүх нийтийн үйлчилгээний төрлийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга, хэрэглүүрийн талаар зөвлөмж гаргах;
  - Бүх нийтийн үйлчилгээний чанарыг үнэлэх аргачлалыг гаргах зэрэг болно.
- 4.3.2. Дараах үндсэн хүрээг хамруулан БНҮҮС-ийн үйл ажиллагааны зарчмыг боловсруулах:
- БНҮҮС-ийн бүтэц, бүрэлдэхүүн;
  - Хэрэгжүүлэх арга хэрэглүүр, дүрэм, журам;
  - Хэрэгжүүлэх үйл явцад тавих хяналтын механизм.

## 5. Хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн

Зөвлөх үйлчилгээг гэрээ байгуулснаас хойш 4 сарын хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлнэ.

| Д/д | Хугацаа                                    | Үр дүн  | Баримт бичгийн хэл |
|-----|--|---|--------------------|
| 1   | Гэрээ байгуулснаас 2 долоо хоногийн дотор  | - Эхлэлийн тайлан   | Монгол/Англи       |
| 2   | Гэрээ байгуулснаас 6 долоо хоногийн дотор  | - Хяналт, үнэлгээний тайлан   | Монгол/Англи       |
| 3   | Гэрээ байгуулснаас 10 долоо хоногийн дотор | - Дунд хугацааны тайлан<br>i. Олон улсын сайн туршлагын талаарх тайлан<br>ii. БНҮҮС-ийн зөвлөмж | Монгол/Англи       |

|   |  |   |              |
|---|--|---|--------------|
| 4 | Гэрээ байгуулснаас 15 долоо хоногийн дотор | - Эцсийн тайлан<br>i. Бүх нийтийн үйлчилгээний бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын талаарх зөвлөмж<br>ii. 4.3.2-ын хүрээнд хэрэгжүүлэх журмын төсөл | Монгол/Англи |
| 5 | Сар тутам /дараа сарын эхний долоо хоногт/ | Ажлын явцын сарын тайлан  | Монгол       |

## 6. Зөвлөх үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлага

Зөвлөх нь дижитал хүртээмж буюу тоон оролцоог хангах чиглэлээр мэргэшсэн, МХХ-ны бүх нийтийн үйлчилгээ болон хүртээмжийн үүргийн талаарх хууль эрх зүй, санхүү, эдийн засгийн өндөр мэдлэгтэй мэргэжилтнүүдээс бүрдсэн байгууллага, аж ахуйн нэгж байна. Энэхүү ажлын даалгаврыг гүйцэтгэхэд шаардагдах ур чадвар, туршлагыг үндэслэн зөвлөхийг сонгон шалгаруулна. Зөвлөхийн бүх нийтийн үйлчилгээ, хүртээмжийн талаарх мэдлэг, ялангуяа хөгжиж буй орнуудад дижитал хүртээмжийг нэвтрүүлсэн туршлагыг нь чухалчилж үзнэ.

Сонирхсон байгууллага дараах ерөнхий шалгуурыг хангасан байна. Үүнд:

- МХХ-ны салбарт 5-аас доошгүй жилийн хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх

Байгууллага нь дараах тусгай шаардлагыг хангасан байна:

- МХХ-ны салбарын бүх нийтийн үйлчилгээ болон хүртээмжийн чиглэлээр 2-оос доошгүй удаа зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан;
- Бүх нийтийн үйлчилгээний сан болон хөтөлбөрийн талаарх бодлого, эрх зүй, зохицуулалтын санаачилага боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиглэлээр Засгийн газрын 2-оос доошгүй төсөл хэрэгжүүлж байсан;
- Дижитал хүртээмжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрт санхүүгийн шинжилгээ хийх 1-ээс доошгүй зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан.

--- о О о ---